



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАТШИРЭЭТ СУМЫН "БАТШИРЭЭТ"
СУМ ДУНДЫН ОЙН АНГИЙН
ДАРГЫН ТУШААЛ**

2025 оны 02 сарын 07 өдөр

Дугаар Б/03

Батширээт сум

Хөрөнгө зарах тухай

Монгол улсын "Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль"-ийн 67 дугаар зүйлийн 67.5 дах заалт, "Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль"-ийн 31 дүгээр зүйлийн 31.4 дэх заалт, Зам тээврийн хөгжлийн сайдын 2024 оны А/24 дүгээр тушаалын 2.1 дүгээр зүйл, Ойн газрын даргын 2024 оны 12 сарын 13-ны өдрийн А/453 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Ой хээрийн түймэртэй тэмцэх чадавхыг сайжруулах төслийн хүрээнд Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Ойн газраас олгосон ой, хээрийн түймэр унтраах багаж, хамгаалах хувцас хэрэгслийг тээвэрлэх, ачих буулгах, ажлыг зохион байгуулж хүлээж авах ажлыг Нярав (П.Оргилмаад) даалгасугай.

2. Ой хээрийн түймрийн багаж хэрэгслийг тээвэрлэх ажлын хөлс болох 1 300 000 (Нэг сая гурван зуун мянган)- төгрөгийг байгууллагын 5937039073 тоот данснаас зарцуулахыг ерөнхий нягтлан бодогч (А.Отгончимэг)-т зөвшөөрсүгэй.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ХАВСРАН ГҮЙЦЭТГЭГЧ



Г.ГАНТУЯА